



COVID-19: NSW муж улсыын нутаг дэвсгэрт хэрэгжих COVID-19-р өвдсөн хүнтэй хамт амьдардаг, эсвэл ойрын хавьтагч болсон үед мөрдөх шинэ дүрэм

Хэрэв та COVID-19-р өвдсөн хүнтэй хамт амьдардаг, эсвэл ойрын хавьтагч болсон боловч COVID-19-н шинж тэмдэг илрэхгүй байгаа бол та өөрийгөө тусгаарлах шаардлагагүй боловч дараах NSW Health-н удирдамжийг мөрдөх ёстой:

- Эмнэлэг, өндөр настны сувилал гэх мэт өндөр эрсдэл бүхий газруудад зочлохгүй байх
- Аль болох гэрээсээ ажиллах буюу суралцах. Ажил эсвэл сургуульдаа зайлшгүй очих шаардлагатай бол ажил олгогч юм уу сургуулиасаа зөвшөөрөл авах
- 12-оос дээш насныхан дотор орчинд маск зүүнэ. Гэхдээ та гэртээ байгаа бол маск зүүх шаардлагагүй.
- Та хамт амьдардаггүй олон тооны хүмүүстэй битүү орчинд хамт байхаас зайлсхийгээрэй. Хэрэв зайлшгүй явах ёстой бол явахаас өмнө түргэвчилсэн шинжилгээ хийгээрэй.

Тантай хамт амьдардаг хүн COVID-19-н эерэг хариуг хамгийн сүүлд авснаас хойш 7 хоногийн турш уг дүрмийг баримтлах шаардлагатай.

COVID-19-н шинж тэмдэг танд илэрвэл та өөрийгөө тусгаарлах ёстой ба COVID-19-н шинжилгээ өгнө үү. Шинжилгээгээр эерэг хариу авсан тохиолдолд NSW Health-н зөвөлгөөг даган мөрдөнө үү.

Хэрэв та сөрөг хариу авсан бол уг авчний шинж тэмдэг арилтал гэртээ байна уу.

Нэмэлт мэдээллийг www.nsw.gov.au/covid-19/management/household-contacts цахим хуудсаар орж авна уу.